

144	гул	пунь	пунь	
145	kuл	кунь	кунь	
146	zhuang weng	чжуан вэн	жуан вен	
147	уи	юй	юй	
	пи	нюй	ньуй	
148	ли	люй	льуй	
149	ли	цзюй	звуй	
	qu	цюй	цвуй	
150	ху	сюй	свуй	
151	уе	юэ	юуэ	
	пе	нюэ	ньуэ	
152	лю	люэ	льуэ	
153	юе	цзюэ	звүэ	
154	que	цюэ	цвүэ	
155	хуе	сюэ	свүэ	
156	уан	юань	юуань	
157	juan	цзюань	звүань	
158	quan	цюань	цвүань	
159	xuan	сюань	свүань	
160	уун	юнь	юунь	
161	jun	цзюнь	звүнь	
162	qun	цюнь	цвүнь	
163	xun	сюнь	свүнь	

Эдгээр нь хятад үгийг кирилл үсгээр хэрхэн галиглах талаархи миний хувийн санал бөгөөд зарим эргэлзээтэй, ярилцамаар зүйл байх тул хэлний мэргэжилтнүүд, хятад хэлний багш нар та бүхэн энэ талаар саналаа солилцон, та бид хамтран ажиглавал нэгдсэн үр дүнд хүрэх болов уу хэмээн найдмой.

ДУНДАД ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛЧУУДЫН ГАДААД ХЭЛНИЙ МЭДЛЭГТ БОЛОВСРОЛ

МУИС, ОУХС-ийн багш
түүхийн ухааны дэд доктор Д.Наран

Монголчууд бол гадны харь хэлийг сурч байсан өнө эртний түүхтэй улс билээ. Манай эриний өмнө III зууны эцэс ба II зууны үед хүннү нар харь оронд элч зарж бичиг илгээж мөн хятадаас ирсэн тайган Чжан Хинюэ гэгчээр хятад бичиг заалгаж байсан ажээ.¹ XIII-XIV зуун бол Монголын төр улс мандаж гадаад харилцаа өргөжин хөгжиж байсан түүхэн үе билээ. Гадаад харилцаа өргөжих явдал аажимдаа гадаад хэлний мэдлэг боловсролтой хүмүүсийг олноор шаардах болж монголын төрийн албанд тухайн үедээ эл талаар чамгүй боловсорсон хүмүүс алба хашиж явсныг түүхэн сурвалж бичгүүд ба эрдэмтэн мэргэдийн бүтээлүүдэд тэмдэглэсэн байх юм. Үүнээс гадна монголчууд гадаад хэл сурах явдлыг чухалчилж байсан тухай сонин мэдээ солонгос түүхийн сурвалжид бий. Жишээ нь, "Гуугин улс руу зугатан орсон хятаны үлдэгдэл цэргийг дарахаар 1218 онд монголын Хабжин нэртэй жанжин Гуугин улсад очоод буцахдаа дөчин нэгэн хүнийг үлдээж солонгос хэл сурахыг сургамжилж байжээ."²

Монголчууд гадаад харилцаандаа монгол төдийгүй бусад орны бичиг үсгийг хэрэглэж гадны элч төлөөлөгчидтэй

¹ БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ, 1966, 95-р тал

² Б.Сумъяабаатар. Монгол-Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд. УБ, 1975, 28-р тал.

харилцахдаа өөрийн орчуулагчидтай байсан тухай Өмнөд Сүн улсын элч Жао Хун 1221 онд Яньжин хотноо хүрэлцэн ирж Мухулай жанжинтай уулзсаны дараа өөрийн бичсэн "Монгол татарын бүрэн тэмдэглэл"-дээ³ "... тэдний улс эдүгээ хүртэл гадаад улс гүрэнтэй харилцах албан бичгээ үйлдэхдээ үйгур бичиг хэрэглэдэг. Бичиг нь хятадын лимбэний аялгууны тэмдэгтэй төстэй. Сүүлийн хоёр жилд Алтан улстай харилцах явдалд хятад бичиг хэрэглэдэг болсон. Тэдэнд албан бичиг үйлдэхэд нь урьд өмнө Алтан улсын түшмэл байсан хүмүүс орогнох газаргүйн эрхэнд тусалдаг. Яньжинд Ила Зиньчин хэмээх хятан хүн бичгийн аливаа хэргийг хамаардаг. Хун бийвээр го-ваны өмнө хоёр ахлах түшмэл байхыг үзлээ. Сяошэн Тэмүр бол зүүн гарын ланжун /ялгалч түшмэл хэмээх албан тушаалын нэр/, Жаны Юй бол баруун гарын ланжун юм. Элч морилогч ирэхэд энэ хоёр хүн яриаг нь орчуулж өгдөг" гэнэ. Мухулайн бичиг хэргийн түшмэл Сяошэн Тэмүр бол шаргачин туулай жил⁴ уг албанд ажиллаж эхэлсэн ажээ. Оросын эрдэмтэн Н.Ц.Мункуев энэ хүнийг монгол хүн байх гэсэн санаа дэвшүүлэхдээ XII-XIII зуунд Тэмүр /Төмөр/ гэдэг нэр монголчуудын дотор өргөн түгээмэл байсан харин Сяошэн гэх нэрийг тайлбарлахад бэрхшээлтэй байна гэжээ.⁵ Сяошэн гэдэг нэр монгол хэлний "цэцэн" гэдэг үг болов уу. Энэ нь хүний нэр эсвэл цол байж болно. Монголчууд бичгийн чадалтай хүмүүсээ "цэцэн", "мэргэн", "сударч" гэхчлэн хүндэтгэдэг⁶ байсныг тэмдэглэх нь зүйтэй. Харин Ила Зиньчин гэдэг нь Елюй Чуцай юм. Зиньчин гэдэг нь түүний өргөсөн нэр болно. Жао Хун тус тэмдэглэлдээ Мухулай ганц хүүтэй. Тэр нь зүс царай сайхан, гадаад орнуудын олон хэлээр ярьж чаддаг байсныг дурьджээ.⁷ "Юанши" /Юан улсын судар/ сурвалж бичигт Мухулайн хүү Борыг олон гүрний хэл мэддэг, морь унах, харваж намнахдаа гарамгай" гэсэн байдаг. Жао Хунаас хойно 1235 онд

монгол газраар зорчсон Өмнөд Сүн улсын элч Сюй Тин, Лан Даа нар "Хар татарын хэргийн товч" тэмдэглэлдээ: "Яньжин хотын сургуулиуд ихэнх нь үйгур бичиг зааж татар хэлнээс орчуулах эрдэмд сургадаг. Сурагчид хоёр хэлнээ орчуулж чаддаг болмогч орчуулагч хэлмэрч болдог... Хятад, хятан, зөрчид зэрэг олон оронд явуулж байгаа нь зөвхөн хятад үсэг буюу" гэжээ. Үүнээс үзэхэд монголчууд аль XIII зууны эхэн хагаст эзлэгдсэн улс орнууддаа хүртэл гадаад хэлний боловсрол олгодог боловсролын байгууллагуудтай болсон байжээ.

1233 онд Өгөөдэй хааны зарлигаар Яньжин хотноо /Одоогийн Бээжин хот/ байгуулагдсан Их Монгол Улсын Хөвгүүдийн сургууль бол монгол болон Монголд дагаар орсон харь гаралтай түшмэд ноёдын хүүхдэд хятад ба монгол хэл заадаг байжээ. Энэ талаар "Сицзиньчи цэи"-⁸ "Сижикий тэмдэглэлийн эмхэтгэл" /гэх хятад сурвалж бичигт сонин баримт байгааг орчуулж үзвэл" хичээлийн цагаар монгол хэлний бус ангийн сурагчид /өөрөөр хэлбэл монгол сурагчид/ зөвхөн хятадаар ярих ёстой, хэрэв хятадаар бус монголоор яривал бичгийн хулсан самбараар нэг удаа цохих, хоёр удаа бол хоёр цохих, гурав удаа давталт гурав, дөрөв удаа давталт дөрөв цохих гэх мэт шийтгэл ноогдуулдаг" байжээ.

Хэлний хичээл монгол хөвгүүдэд бэрхшээлтэй байсныг мөн өгүүлсэн байдаг. Орчуулбал: "бичээч" болох хөвгүүдэд хятадын хэл бичиг, ном зохиолоос зааж хэрэв үсэг бичиг сурахад бэрхшээлтэй бол хүнд хэцүү үг үсэг бүү заагтун. Хэрэв амарханыг нь сураад авбал муу нь юу байх вэ" гэсэн байна. Цааш өгүүлэхдээ "бичээч бологсод нь хятад хэлийг эзэмшин ярьж хэлэхдээ орчуулагч Хутуг шиг болох, хоёр хэлийг нэвтэрхий төгс эзэмшсэн бол орчуулагч хэлмэрч хий" гэсэн утгатай сонин баримт болно. Тэр үед Хутуг гэх нэртэй монгол хүн хятад хэлний мэдлэг боловсролоороо монголчуудын дунд үлгэр жишээ үзүүлж явжээ.⁹

Монгол хаад ноёд ч бас гадаад хэлний мэдлэгтэй байж. Жишээ нь, Их Монгол улсын Мөнх хаан гадаадын элчийг хүлээн авч уулзахдаа тэдний авчирсан бичиг захидлыг өөрөө уншиж танилцах явдал нэг биш удаа үзэгджээ.⁹

³ "Мэнча бэйлу". Наука. М. 1975, перевод Мункуева Н.Ц. 66-р тал

⁴ Шаргачин туулай бил бол 1219 оны 1-р сарын 18-аас 1220 оны 2-р сарын 5 юм

⁵ Н.Ц.Мункуев. Китайский источник о первых монгольских ханах. Надгробная надпись на могиле Юлюй Чуцай. Наука. М. 1965, 132-р тал

⁶ Х.Нямбуу, Ч.Арбаясүрэн. Монгол ёс заншлын их тайлбар толь. Тэргүүн боть. УБ 1992, 128-р тал

⁷ "Мэн-да бэйлу". Наука. М. 1975. Пер. Н.Ц.Мункуева. 60-р тал

⁸ Сюй Мансян. "Сицзиньчи цэи" Бэйцзин 1981

⁹ Н.Ишхамид. Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ. 1976, 87-р тал.

Дээрх баримтуудыг нягтлан дүгнэвээс бидний өвөг дээдэс хүртэл харь улсын хэлийг чухалчлан үзэж эл талын мэдлэг боловсролтой хүмүүсийг сургаж бэлтгэж байсан баялаг туршлагатай ажээ. Иймд монголын гадаад хэлний сургалт бол эртний түүхтэй агаад наанадаж дундад зуун цаанадаж хүннүгийн үеэс эхлэн тооцогдох ёстой ажээ.

Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРСАМЖ

АЛТАН АРГАМЖ

VOL.3

1/2000

БОЛЗМОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ

МУИС, ОУХС-ийн багш
С.Сүхээ

Шинжлэх ухаан техникийн үсрэнгүй хөгжлийн эрин үед нийгмийн хэл шинжлэлийн гүйцэтгэх үүрэг улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай болж байна. Үүний нэг тод жишээ бол эрдэмтэд хэлийг хүн төрөлхтөний галцхүү харилцааны хэрэглүүр биш харин аливаа нэг улс орны хөгжил, түүний ард олны оюуны болон техникийн үйл ажиллагааг цаашид боловсронгуй болгох арга хэрэгсэл болгон авч үзэж байгаад оршино.

XX зууны 70-аад оноос эхэлж улмаар 80-аад онуудад эрч хүчээ авч байгаа манай гаригийн ихэнх орныг хамарсан нийгмийн дунд хурдацтай дэлгэрч буй зохиомол (болзломл) хэл нийгмийн хэл шинжлэлийг тойрон гарсангүй. Энэ бүгд нь нийгэм хэл хоёрын харилцан уялдаа холбоог зайлшгүй судлан үзэх нийгмийн хэл шинжлэлийн хойшлуулшгүй гол асуудлын нэг болон гарч ирэв. Нийгмийн хэл шинжлэлийн нэг салшгүй салбар нь нийгмийн аялгуут хэл бөгөөд түүнд хамаарагдах зохиомол хэл болох этгээд хэл нь олон орны эрдэмтдийн анхаарлын гадуур өнгөрөх ёсгүйг харуулах болжээ. Гаж буруу үг хэллэгээс (англиар-слэнг, оросоор блат буюу фэня г.м.) бүтдэг этгээд хэлийг манай хойд хөрш орны эрдэмтэд хэдийнээ судалж ирсэн хэдий ч эрчимтэй судалгааг 1980-аад оны дунд үеэс эхэлсэн билээ. Манай орны хувьд нийгмийн хэл шинжлэлийн энэ салбарт цагдаагийн дээд